



УДИРДАГЫН
АКАДЕМИ

Худалдан авах ажиллагаан дахь нийтлэг зөрчил, түүнээс сэргийлэх арга зам

Улаанбаатар хот
2018 он

АГУУЛГА

- Худалдан авах ажиллагааны онолын үндэс, эрх зүйн зохицуулалт
- Худалдан авах ажиллагаан дахь нийтлэг зөрчил
- Худалдан авах ажиллагааны зөрчлөөс сэргийлэх арга зам



Худалдан авах ажиллагааны онолын үндэс: Фридманы мөнгөний онол



1. Өөрийн мөнгөөр өөртөө
2. Өөрийн мөнгөөр хүнд
3. Хүний мөнгөөр өөртөө
4. Хүний мөнгөөр хүнд

Худалдан авах ажиллагааны онолын үндэс: Фридманы мөнгөний онол

	Хэмнэлт	Чанар
Өөрийн мөнгөөр өөртөө		
Өөрийн мөнгөөр хүнд		
Хүний мөнгөөр өөртөө		
Хүний мөнгөөр хүнд		

Худалдан авах ажиллагааны онолын үндэс: Сонирхлын зөрчил

Төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлэх

Хэмнэх

Үрэлгэн зарах

Хамгийн сайн сайхан зүйл худалдан авах

Өндөр шаардлага

Бага үнэ

Худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх

Үр ашигтай

Хувийн сонирхол

Худалдан авах ажиллагааны онолын үндэс: Сонирхлын зөрчлөөс сэргийлэх

**Олон улсын нийтлэг
стандарт**

Хууль, журам

Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалт

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (ТБОНӨХАҮХАТ)
- Иргэний хууль
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Захиргааны Ерөнхий хууль
- Эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт

Худалдан авах ажиллагаан дахь НИЙТЛЭГ ЗӨРЧИЛ

- Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулдаггүй
- Худалдан авах ажиллагааны ил тод байдал хангалтгүй
- Нээлттэй тендер шалгаруулалт явуулахаас зайлсхийж, харьцуулалтын болон шууд гэрээ байгуулах аргыг түлхүү хэрэглэх хандлагатай
- Захиалагч, гүйцэтгэгчийн хариуцлагагүй байдлаас өмнөх зөрчил давтагддаг
- Зураг төсөв нь шаардлага хангаагүй, газрын зөвшөөрөлгүй, техникийн нөхцөл нь баталгаажаагүй төслийн худалдан авалтыг эхлүүлдэг
- Үнэлгээний хороонд хөндлөнгийн төлөөллийг оролцуулдаггүй

Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулдаггүй

- ТБОНӨХАҮХАТ-ын 27,28,29 зйлд
заасан журмыг зөрчих

Нээлттэй тендер шалгаруулалт явуулахаас зайлсхийж, харьцуулалтын болон шууд гэрээ байгуулах аргыг түлхүү хэрэглэх хандлагатай

- **Захиалагч тендерийн баримт бичгийн үнийг үндэслэлгүй өндөр тогтоодог.**

Худалдан авах ажиллагаан дахь нийтлэг зөрчил ...

- Үнийн санал ирүүлсний дараа урилга хүргүүлсэн;
- гүйцэтгэгчийг шалгаруулах тухай зөвлөмжийг үнийн санал ирүүлэхээс өмнө хүргүүлсэн;
- Гэрээ байгуулах мэдэгдлийг гүйцэтгэгчийг шалгаруулах тухай зөвлөмжөөс өмнө хүргүүлсэн зөрчил гаргасныг аудитаар тогтоосон
- Гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэхдээ тендерт оролцогчид тавих шаардлагыг хангаагүй этгээдийг шалгаруулдаг
- Тендерийн хавтаст хэргийг бүрэн бүрдүүлэхгүй, архивын нэгж болгохгүй байх нь элбэг
- Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд талуудын хяналт хангалтгүй

Худалдан авах ажиллагааны зөрчлөөс сэргийлэх арга зам

- Худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлж ажиллах
- Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, хэмнэлттэй, үр ашигтай, хариуцлагатай байх зарчмын дагуу зохион байгуулах
- Захиалагч, үнэлгээний хороо хуулиар олгогдсон эрх, үүргээ хариуцлагатайгаар хэрэгжүүлдэг байх
- Тендер шалгаруулалтын аргуудыг хуульд нийцүүлэн зөв хэрэглэдэг байх
- Худалдан авах ажиллагааны төлөвлөх, тайлагнах журмыг чанд мөрдөж ажиллах, түүнд тавих хяналтыг үр дүнтэй болгох

Тохиолдол

- Тухайн оны 2 дугаар сарын 5 –нд Үнэлгээний Хороо А компанийг “Хамгийн сайн” үнэлгээтэй тендерт оролцогч гэж шалгаруулан захиалагчид гэрээ байгуулах зөвлөмжийг хүргүүлснээр захиалагчийн албан бичгээр А компанид гэрээ байгуулах эрх олгосон. А компани нь мэдэгдэлд заасан хугацаанд банкны гүйцэтгэлийн баталгааг хүргүүлж, мөн гэрээнд гарын үсэг зурж, тамга тэмдгээ дарж, захиалагч талаас баталгаажуулахаар 2 хувь гэрээг захиалагчид үлдээсэн байна. Гэрээг баталгаажуулах дээд шатны байгууллага гэрээ байгуулахаас татгалзав. Татгалзсан үндэслэл нь тухайн онд хийгдэх тендерийн санжүүжилтийг зогсоох тухай эрх бүхий байгууллагын шийдвэр гарчихаад байхад Үнэлгээний Хороо тендер шалгаруулсан гэжээ. Гэтэл сарын дараа дахин нээлттэй тендерийг захиалагч нийтэд зарласан.

Шийдэл

Нэгэнт төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас зарласан ажил гүйцэтгэгч сонгон шалгаруулалтад зүй ёсоор шалгарч, “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерт оролцогч “А компанитай -тай гэрээ байгуулах эрх олгогдсон байхад захиалагч хууль бусаар гэрээ байгуулахаас татгалзсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т “Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 5-аас доошгүй хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулна”, 46 дугаар зүйлийн 46.1.3-д “захиалагч нь үнэлгээний хорооноос гаргасан дүгнэлтэд үндэслэн гэрээ байгуулах эрх олгох шийдвэр гаргах эрхтэй”, 47 дугаар зүйлийн 47.2.2-т “Үнэлгээний хороо нь тендерийг хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийг захиалагчид өгөх. Уг шийдвэрийг энэ хуулийн 46.2-т заасан захиалагчийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан үндэслэлгүйгээр өөрчлөхийг хориглоно” гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Тайлбар

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3-д «Хамгийн сайн» үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч гэрээ байгуулахаас татгалзсан, эсхүл гэрээ байгуулах эрх олгосон мэдэгдэлд заасан хугацаанд гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй нөхцөл үүссэн бол түүнд олгосон гэрээ байгуулах эрхийг захиалагч хүчингүй болгохоор заасан ба үүнээс өөр тохиолдолд гэрээ байгуулахаас татгалзах эрхгүй юм.